



“Авилгатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь: Асуудал ба шийдэл” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хурал.

Сэдэв **“Авилгын эсрэг атгасан гар мэт”**

Монгол улсын шинжлэх ухаан технологийн их сургууль, ГГТС-ын “Хийн дамжуулалт-хангамжийн” ангийн 1-р курсын оюутан
Батжаргал овогтой Адъяасүрэн

Улаанбаатар хот 2011 он

Илтгэлийн бүтэц.

- ✓ Оршил
- ✓ 1-р хэсэг “Асуудал ба шийдэл”
- ✓ 2-р хэсэг “Авлигын талаарх иргэдийн санал бодлыг судалсан нь”
 - 2.1 Судалсан судалгааны арга зүй ба сонгож авсан байдал
 - 2.2 Судалсан судалгааны үйл явц
 - 2.3 Судалгааны дүгнэлт
- ✓ 3-р хэсэг Илтгэгчийн дэвшүүлж буй төсөл хөтөлбөр
- ✓ Ерөнхий дүгнэлт
- ✓ Ном зүй, ашигласан материал.

Оршил

Эрхэм хүндэт ноёд хатагтай нар аа!

Та бүхний түмэн амар амгаланг айлтгая!

Өнөөдөр та бид улс орныхоо ирээдүйн хөгжил дэвшилд нэн хамааралтай нэгэн чухал асуудлыг хэлэлцэхээр хуран цуглараад байна.

Энэхүү оюутны эрдэм шинжилгээний бага хурлын агуулга, ач холбогдлыг товчхондоо нэр нь илэрхийлж байгаа гэж хэлж болно.

Юуны өмнө энэ эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан Авлигатай тэмцэх газар, түүнийг дэмжин оролцсон Монгол улсын бүх шатны Их дээд сургуулийн удирдлага, хамт олонд талархлаа илэрхийлье.

Улс төр, нийгэм, эдийн засаг, ер нь нийгмийн бүхий л салбарт хор хөнөөлөө тусгаж, уруудаж доройтохын шалтгааныг тарьдаг нийгмийн энэ аюулт үзэгдэл орчин үед нэг улс орны бус, дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудал болжээ.

Хүйтэн дайны үе дуусч, дэлхийн даяаршил эрч хүчээ авсан сүүлийн хориод жилд улс түмний харилцаанд урьд өмнө байгаагүй нэн таатай нөхцөл бүрдэж, хөгжил дэвшлийн сайхан боломж нээгдсэн хэдий ч түүнийг дагасан сөрөг үзэгдлүүд мөн даяарших болсны нэг нь **авлига** юм.

Тэгвэл өнөөдрийн бага хурлын гол сэдэв болох **авлигын** тухай хуулийн заалт нь:

“Авлига гэж албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил” гэж заажээ.

Манай улсын хувьд авлигатай тэмцэх талаар гар хумхин суугаагүйг 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг тус тус батлан гаргаж мөрдүүлснээс тод томруун харж болно.

Гэхдээ үр нөлөөг нь авсан арга хэмжээний тоо, хэлбэрээр нь бус түүний үр дүнгээр хэмжих ёстой гэдэг үүднээс харвал улс орны хэмжээний авлигын нөхцөл байдалд дорвитой өөрчлөлт гарсангүй. Хууль тогтоомжийн хэрэгжилт ч дутуу дулимаг байгааг, хууль хяналтын байгууллагуудын шалгасан, шийдвэрлэсэн ажлын дүн мэдээ нийгэм дэх авлигын бодит нөхцөл байдалтай тэр болгон нийцэхгүй байна гэж иргэд шүүмжилж байна.

Нэг ийм хошин яриа байдаг юм:

Монголчууд эрт дээр үеэсээ авилгалч байсан нь:

-Танилтай хүн талын чинээ, танилгүй хүн алгын чинээ.

-Зуун төгрөгтэй явснаас зуун нөхөртэй яв гэх мэтийн зүйр цэцэн үгсээс илт мэдрэгдэж байгаа юм.

1-р хэсэг: Асуудлыг шийдэх нь

Авилгал хэмээх нэр үг арван жилийн өмнө төдийлөн танил биш, чихэнд ч наалдац муутай үг байсан бидний хувьд харин өнөөдөр дэлгүүр хоршоо шиг л энгийн сонсогдох боллоо. Монголын амьдралд энэ үг ингэтлээ гүн шингэж чаджээ. Хүнд юм өгөхөд юу нь муу байх вэ, нэгнийх нь ч гэсэн амьдрал дээшилж байхад болохгүй нь юу билээ гэж бодож өдий хүрсэн Монгол хүний уужуу гэмээр ч юм шиг, өнгөц гэмээр ч юм шиг сэтгэлгээ нь энэ авилгал хэмээх зүйлийг үжиж ургах таатай нөхцөл нь ч болсоор ирлээ.

Нөгөө талаасаа өөрийн ажлаа л бүтээж байвал бусдынх хамаагүй мэтээр ханддаг дутагдалтай гэхээсээ илүү аймшигтай зан бидэнд бий. Гэтэл бид нэгэнт нийгэмшиж амьдраад эхэлсэн улс шүү дээ. Нэг нуурын ус бохирдвол тэнд амьдарч буй загас жараахай бүгдээрээ л хордох нь тодорхой. Тиймээс нэг хүний хийсэн бохир үйлдэл бусдыгаа хохироогоод зогсохгүй нэг өдөр өөрийг нь эргээд хохироож эхэлдэг энэ харилцааг нийгэмшил гээд ойлгочиход болно.

Өнөөдөр аль ч улсад авилгал гэдэг нь онц хүнд гэмт хэрэгт тооцогдож хамгийн хатуу шийтгэлүүдийг хүлээж байгааг харахад Монгол хүний ярьдгаар ямар ёроолгүй нүгэл хийчихсэн хүн ингэж шийтгүүлдэг юм болоо гэж бодогдох. Гэвч олон талаас нь бодож, хол ойрыг харьцуулж байх нээ энэ үнэхээр том гэмт хэрэг, адгийн нүгэл мөн юм байна гэсэн бодол төрж явдгаа та бүхэнтэй хуваалцъя.

Авилгалыг сайн юм дагадаг байсан бол хүн төрөлхтөн дэмжээд аваад явах нь тодорхой. Гэтэл ингэдэггүйгээр үл барам харин муу бүхнийг нийгэмд тарьж ургуулдаг хорт үзэгдэл учраас хүч тавин тэмцдэг нь аргагүй юм. Авилгал хаана их байна вэ?, тэнд хөгжил дэвшил нурж, хүчирхийлэл, аллага, хулгай дээрэм, завхрал бүхэн харанхуй газрын чийгний хөгц шиг үжин ургаж байдаг.

Авилгалдаа идэгдсэн орнууд өнөөдөр дэлхийн хамгийн ядуу, хөгжил буурай нэгэн болцгоож хүн ард нь өвчин зовлон, үгүйрлийн туйлд унацгааж байна. Тэдний дунд бүр байгалийн баялгаараа дэлхийд толгой цохидог байсан орнууд ч бий.

Ардчилсан нийгэм байгуулж эхэллээ гэж тунхагласнаас хойш 20 жил өнгөрөхөд Монгол улс үндэсний үйлдвэрлэлээ, үндэсний үйлдлвэрлэлийн өрсөлдөх чадамжаа бүрэн устгасан гэгддэг.

Өмч хувьчлал нь манай улсад авилгал дэлгэрэх хамгийн том үйл явц болсон бөгөөд тэр үед чадалтай, бизнес удирдаад олон хүний хувь заяаг үүрээд явчих менежментийн багт өгье гэхээсээ илүү мөн л авилгалаар гараа атгалцсан хүмүүсийн хоорон дахь наймаа болсноос үйлдвэр нь хаагдаж, ажилчид нь гудамжинд гарцгаасан

Ер нь бол авилгачид юм бүтээдэг хүмүүс байдаггүй, тэд харанхуйд амьдардаг шөнийн араатан, шавьжны шинжтэй л улс. Үйлдвэр албан газрууд тийнхүү олноор хаагдснаар аргагүй эрхэнд хэчнээн хүмүүс гэр орноосоо хол олон жил гадаадад ажиллав, хэчнээн хүн ажил амьдралгүй болж архичин болцгоов, хэчнээн хүүхэд тогтсон орлогогүй аав ээжийн гар дээр өлөн зэлмүүн өсөж байна вэ. Авилгачид хэдэн мянган өрх гэрийн талхыг, гэр бүлийн хамтдаа байх халуун аз жаргалыг үгүй хийж байна вэ?

Гэтэл тэдгээр нийгмийн харанхуйд амьдрагч шөнийн араатны хажууд хүн дээрэмддэг, тонуулчин бол цагаан гартан.

Улс төр, нийгэм, эдийн засаг, ер нь нийгмийн бүхий л салбарын хөгжилд өчүүхэн зүйл ч агуу зүйлийн жагсаалтанд ордог.

Тэгвэл би улс төр, эдийн засаг, инфляци, валютний ханш гэж том асуудал сөхөхгүйгээр энгийн хэдхэн жишээг дурдъя.

Манай улсад **эрүүл мэндийн** болоод **боловсролын** салбараа өөд нь татах шаардлага үнэхээр их байна.

Харин тэнд ажиллаж байгаа багш, эмч нарыг авилгалд холбогдуулан ярихыг оролдох нь нийгмийн анхаарлыг өөрсдөөсөө холдуулах гэсэн жинхэнэ авилгачдын оролдлого байж болох юм.

Юм уншдаг, насан туршдаа оюунаа боловсруулж явдаг хүмүүс ийм бусармаг үйлдэлд өөрсдийгөө оруулдаггүй юм. Харин төр ивээлдээ авдаг гэх

эдгээр салбарт урагшгүй байдал их байгаа нь мөн л төртэй хутгалдсан авилгалтай шууд холбоотой.

Эмнэлгүүдэд л гэхэд хамгийн сүүлийн үеийн сайн технологи, тоног төхөөрөмж оруулж ирэх бололцоо байсан ч тэр мөнгийг өөр голдрил руу урсгадаг этгээдүүд байгаагаас хэчнээн хүн онош нь тодрохгүй өвчнөө хүндрүүлж хорвоог орхив, хэчнээн хүнийг эмчилж амьдрал бэлэглэх байсан эмч нар аргагүйдэж хүч мөхөсдөв, хэчнээн хүний ар гэр, амьдралд гуниг харуусал үлдэв. Үүнд хэн буруутай вэ?

Боловсролын хувьд гэхэд л дэлхийн хаана ч гологдохгүй чадалтай залуус миний эх орон Монголд олон бий. Гэхдээ түмэн нүдтэй гэгддэг төр маань ихэнх тохиолдолд тэднийгээ олж харж, өөртөө ашиглаж чадахаа байжээ. Гадаадын томоохон их дээд сургуульд тэтгэлгээр суралцаж байгаа оюутнууд жинхэнээрээ шилэгдэж явж байна уу гэвэл үгүй л болов уу, дийлэнх нь авилгачдын хүүхдүүд, төрөл садангууд байна. Бор зүрхээрээ өөрийгөө борлуулж яваа залуус нь харин эгэл жирийн айлын хүүхдүүд байх нь олонтой.

Авилгач гэр бүлд өссөн хүн юм сурч гийгүүлэх нь тун ховор. Ихэнх нь зугаа цэнгэл, аар саар зүйлээр оролдон их сайндаа л нэг буруу хазгай англиар ярьж сурдаг юм билээ.

Авилгачид бидний мөнгөөр дараа үеийн авилгачдаа бэлдэж эхэлж байна. Олон сайхан шилэгдмэл залуусыг өндөр боловсролтой болгоход зарцуулж болох байсан мөнгийг амин хувьдаа зувчуулж улс орныг мунхаг харанхуй руу түлхсэн, олон хүний алтан амийг аварч болох байсан мөнгөөр авгай хүүхдээ гадаадад шоппингдуулсан тэр этгээдүүдийн дэргэд траншейнд амьдардаг борчууд хамаагүй цэвэрхэн, ариун улс.

Энэ хэний буруу вэ?

Сүүлийн үед авилгалтай холбоотой сонсогдох болсон хамгийн гунигтай мэдээ бол цагдаа, шүүх, прокурорын байгууллагууд авилгалд идэгдэж байгаа тухай юм. Арай ч дээ, мөнгөөр үнэлэгддэг зүйл, үнэлэгддэггүй зүйл гэж бий шүү дээ. Мөнгө хэдийгээр маш чухал ч энэ нь зүгээр л төлбөрийн баталгаа болж байдаг

хэрэгсэл. Хууль сахиулах ажилтнууд авилгалд идэгдсэнээр гэмт хэргийг таслан зогсоодог биш, харин тарьж ургуулдаг хамгийн арчаагүй нүглийн эзэд өөрсдөө болж, өргөст торны цаана сууж буй ялтнуудаас ч илүү хүнд гэмт хэрэгтнүүд болж байгаа нь тэр.

Авилгачдын бас нэг хортой үйлдэл нь тэд буруу аргаар орж ирсэн мөнгөө мэдэгдчихгүй, олны хараанд өртүүлэхгүйн тулд гадаадад байшин сав, бизнес худалдаж авах, өндөр үнэтэй гадаадын сургуульд хүүхдүүдээ сургах, стратегийн томоохон асуудлаар хилийн чанадад нууц наймаа хийх зэргээр шууд мөнгө гадагш нь зувчуулж улсын эдийн засагт ноцтой хохирол тарьдаг. Энэ мэт үйлдлийн үр дүнд хуучин социалист улсуудаас гадагшилсан хэдэн арван тэрбум долларын хөрөнгө хориодхон жилийн дотор барууны улсуудад байршаад байгаа. Тиймээс манай Авилгатай тэмцэх газар болон санхүүгийн хяналтын байгууллагууд ч гадагшаа урсаж байгаа хөрөнгийн гарал үүсэлд онцгой хяналт тавих цаг болсон. Энэ мэт нийгмийн хөгжлийг урагшаа бус арагшаа татаж байгаа авлигалын тухай бусармаг зүйлсийг дурьдвал нэгэн их боть болох бизээ.

2-Р ХЭСЭГ: “Авлигалын талаарх иргэдийн ойлголтыг судалсан нь ”

Судалгааны зорилго:

Улс эх орны нийгмийн хөгжлийг авлигын муу муухай хэрхэн доош нь татаж байгаа талаар иргэдийн санал бодлыг хуваалцаж, иргэдийн авлигатай тэмцэх хуулийн талаар болон хуулийн хэрэгжилтийн талаарх мэдлэгийг судалж авлигын үр

дагаварын тухай /25-35/ болон /35-дээш/ насны иргэдийн үзэл бодолтой харьцуулан дүгнэлт хийхэд оршино.

Судалгааны ажил:

Энэхүү судалгаанд маань 25-35 насны болон 35-дээш насны нийт 40 насанд хүрэгчид оролцсон.

Судалгааны объект:

- Насанд хүрэгчид /25-35 насныхан/
- Насанд хүрэгчид /35-дээш/

Судалгааны арга:

- Асуулгын арга /нээлттэй/
- Ажиглалт

Судалгаа авсан хугацаа:

2011 оны 11 дүгээр сарын 18наас 11 дүгээр сарын 25

**“Авлигалын талаарх иргэдийн ойлголтыг
судалсан судалгаа” /Үйл явц/**

Судалгааны дүгнэлт

Уг судалгаанд 30 гаруй насанд хүрэгчид оролцлоо. Манай ихэнх иргэд судалгааны арга зүй болон судлагдах арга барил муутайгаас судалгаанд дутуу дулимаг хандах хэв маяг ажиглагдсан.

Судалгааг 25-35 болон 35-аас дээш насны гэж ангилан авсан.

Иргэдээс авсан судалгаанаас үзэхэд авлигын тухай хуулийн мэдээлэл сул, хуулийн хэрэгжилтийн талаар мэдлэг дутмаг, хэнд хандхаа мэддэггүй, гэх зэрэг олон зүйлс мэдрэгдсэн.

Та авлигал хээл хахуульд өртөж байсан уу? Тийм бол хэрхэн яаж гэсэн асуултанд Тийм гэж хариулсан ихэнх иргэд эрүүл мэндийн болон боловсролын салбарт бүр цаашлаад эрүүгийн салбарт авлигал өгч байсан нь Монголын нийгэмд авлигал гэх том модны үндэс хэр урт ургасан байгааг тод томруунаар харуулж байна.

Судалгааны дүгнэлтээс иргэдэд авлигын тухай хууль тогтоомж арга хэмжээ, ял шийтгэлийн талаарх мэдээ мэдээлэл дутмаг байгаагаас авлигалын цар хүрээ ихсэж байгаатай холбогдуулан нэгэн төсөл хөтөлбөрийг сонгосон юм.

Төслийн нэр: Авлигалын эсрэг атгасан гар мэт.

Төслийн зорилго: Ард иргэдийн дунд Авлигал-Хээл хахуулын талаарх үнэн зөв ойлголттой болгох.

Авлигын эсрэг хуулийн тухай хэрэгжилтийг сайжруулах, хуулийн талаарх үнэн зөв мэдээллийг олгох, иргэдийг ажилтай болгох.

Төслийн үе шат:

Уг төсөл нь нийт 3 үе шаттайгаар явагдана.

Үе шат 1: Авлигатай тэмцэх хууль болон түүний хэрэгжилт Авлигатай тэмцэх газар

/АТГ/-ын үйл ажиллагааг олон нийтэд таниулах, иргэдтэй хамтран ажиллах. Иргэдэд хуулийн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, тусалж дэмжих.

Үе шат 2: Сонирхсон иргэдтэй хамтран сургалт семинар явуулж, АТГ-ын үйл ажиллагааг сайжруулах.

Үе шат 3: Сургалтын төгсгөлд хамтран ажиллах хүсэлтэй иргэд хувь хүмүүстэй түншлэлийн гэрээ байгуулж ажлын байранд урих.

Төсөлд хэн хамрагдах вэ?

Төсөлд хамрагдах сонирхолтой, ажиллах бүрэн чадвартай, өөрийн гэсэн чиг зорилготой, авхаалжтай, Монгол улсын иргэн, 21 ба түүнээс дээш насны хүн бүрийг урьж байна.

Төслийг зохион байгуулагч:

Монгол улсын Авлигатай тэмцэх газар.

Төсөлд хэрхэн хамрагдах вэ?

Өөрийн харъяа сум дүүргийн Авлигатай тэмцэх газрын /АТГ/-ын үүрийн штаб дээр очиж үнэ төлбөргүй бүртгүүлнэ үү!

Төслийн үргэлжлэх хугацаа:

Эхний шатны арга хэмжээ: 14-28 хоног.
Хоёрдугаар шатны арга хэмжээ: 1-3 сар.
Гуравдугаар шатны арга хэмжээ: 1-2 сар.

Төслийг санхүүжүүлэгч:

Монгол улсын засгийн газар.
Монгол улсын авлигатай тэмцэх газар.
Төслийг дэмжсэн хувь хүн албан байгууллагуудыг урьж байна.

Төслийн эхлэх хугацаа:

2012 оны III-р улирал.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.iaac.mn веб сайтаас хүлээн авч үзнэ үү.

Ерөнхий дүгнэлт

Авлигал бол “Эдэд шунах, ёсон бус аргааг юмыг олзолж авах” гэж Я.Цэвэл гуайн Монгол хэлний тайлбар тольд бичсэн байдаг.

Эрхэм хүндэт ноёд, хатагтай нар аа!

Та бид Эх орныхоо эрчимтэй хөгжил дэвшлийн шийдвэрлэх шинэ үе шатанд тулж ирлээ. Хориодхон жилийн өмнөөс хоёр нийгмийн тогтолцооны ялгааг даван туулах

ажил эхэлж байсан бол бид шилжилтийн энэ үеийн гол хүндийг хамтын хүчээр нугалан ардаа үлдээж чадсан. Авлигын хорт үзэгдлийг дадал зуршлаасаа таягдан хаяхгүй, хууль дээдлэх зарчмыг жинхэнэ ёсоор нь дагаж мөрдөхгүй, ёс зүйн шаардлагад нэг мөр захирагдахгүй, төр иргэний хиргүй тунгалаг итгэлцэл, түншлэлгүйгээр цаашдын нийгмийн үсрэнгүй хөгжилд хүрч үл чадна. Иймд улс орноо авлигаас ангижруулан, нийгмээрээ цэвэр тунгалаг, сэтгэл санаа амар амгалан, уур бухимдалгүй аж төрөх сайхан цагийг аль болох хурдан цогцлоон улсаа тогтвортой хөгжүүлж, ард түмнээ амаржуулан жаргаах үйлст бүх нийтээрээ эв эеийг хичээн, хамаг хүчээ нэгтгэн зүтгэж, хувь нэмрээ оруулахыг та бүхэнд уриалж байна.

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь: Асуудал ба шийдэл” сэдэвт Оюутны эрдэм шинжилгээний бага хурлын ажиллагаанд амжилт хүсье. Улс оронд маань авлигагүй төр, шударга ёсны сайн үйлс дэлгэрэх болтугай.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ном зүй: -Д.Ариунбаяр “Цаг үе нийгэм” УБ 2007

[-www.iaac.mn](http://www.iaac.mn) “Авлигатай тэмцэх газрын веб сайт”

**-Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн “Цагийн хүрд”
мэдээллийн хөтөлбөр**